



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/24

Хужирт сум

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн
байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд зарим
арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, аймгийн Засаг даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд авах зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай А/63 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн Онцгой комиссоос аймаг, сум хооронд зорчих автотээврийн хөдөлгөөнийг хориглох шийдвэр гарсантай холбогдуулан сумаас орох, гарах хөдөлгөөнийг 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 18⁰⁰ цагаас 02 дугаар сарын 20-ны өдрийн 06⁰⁰ цаг хүртэл, сумын төв доторх иргэдийн зорчих хөдөлгөөнийг 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 08⁰⁰ цагаас 02 дугаар сарын 15-ны өдрийн 06⁰⁰ цаг хүртэл тус тус хязгаарласугай.

2. Хөдөлгөөн хязгаарласантай холбоотойгоор сумын төвийн 6 хяналтын цэг, Шуурхай штабыг хуваарийн дагуу ажиллуулсугай.

3. Дээрх хугацаанд хүнс, барааны дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг оройн 17⁰⁰ цаг байхаар хязгаарлалт тогтоосугай.

4. Улаанбаатар хот болон голомтот бүсээс нийтийн тээвэр, хувийн тээврийн хэрэгслээр ирэх иргэдийг 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийг дуустал татан авч, 14 хоногийн гэрийн тусгаарлалтад орох иргэдийн гар утсанд цахим хяналтын (TRACKER gps) программыг суулгаж хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Дэмбэрэл), Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Э.Оюунпүрэв), багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Хяналтын цэгт ажиллах албан хаагчдын хоол, хүнс, шатахууны зардлыг сумын Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Дэмбэрэл), Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ